



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Цэцэг сумын цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХОА-2025/043/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)

Ховд хот  
2025 он

Төрийн аудитын газрын

дарга, тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар

Утас: 70433061 Цахим хаяг: boldbaatarkh@audit.gov.mn

Аудитын менежер: А.Цэцэгсүрэн

Утас:70432545 Цахим хаяг:tsetsegsurena@audit.gov.mn

Ахлах аудитор: Ц.Бадрал

Утас:70432545 Цахим хаяг: badralts@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



### ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд  
Утас: 976-70433061, Факс: 976-70433061  
E-mail: khovd@audit.gov.mn

2025.02.17 № 02/36  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ХОВД АЙМГИЙН ЦЭЦЭГ СУМЫН,  
ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН  
ЭРХЛЭГЧ Ч.БУЯНДЭЛГЭР ТАНАА

#### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Ховд аймгийн Цэцэг сумын хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Ховд аймгийн Цэцэг сумын хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд хоол хүнсний зардалд 98,279.4 мянган төгрөг батлагдаж, 95,474.2 мянган төгрөгийг зарцуулсан нь өнгөрсөн оноос 23.0 хувиар өссөн нь хүүхдийн хоолны зардлын норматив 2024 оны 09 дүгээр сараас 3000 төгрөг болсонтой холбоотой байна.

#### Аудитын гол асуудал

Тайлант онд төрийн албан хаагчийн цалин хөлс нэмэгдсэн ба улсын төсвөөс 1,166,982.6 мянган төгрөг батлагдаж, 1,117,803.7 мянган төгрөгийг зарцуулсан нь өмнөх оноос 36.1 хувиар өссөн байна.

#### Бусад асуудлын хэсэг

Тайлант онд гүйцэтгэлийн төлөвлөгөөг 11 зорилтын хүрээнд 53 дэд арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 2024 оны эцэст 99.1 хувиар биелэлттэйгээр тайлагнасан байна.

#### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ХҮНДЭТГЭСЭН: ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Х.БОЛДБААТАР

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(Төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>109,657,262.26</b>	<b>200,525,637.87</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	38,781,104.46	106,027,358.57
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	38,781,104.46	106,027,358.57
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	38,781,104.46	106,027,358.57
31211	Төрийн сангийн харилцах	38,781,104.46	106,027,358.57
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	700,000.00	-
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	700,000.00	-
3352	Хувь хүмүүсээс авах авлага	700,000.00	-
<b>34</b>	<b>УРЬДЧИЛГАА</b>	9,358,635.40	3,666,891.40
<b>3471</b>	<b>Урьдчилгаа тооцоо</b>	9,358,635.40	3,666,891.40
34713	Цалингийн урьдчилгаа	9,358,635.40	3,666,891.40
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	60,817,522.40	90,831,387.90
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	478,300.00	478,300.00
35130	Эм боох материал	478,300.00	478,300.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	50,362,502.40	75,173,887.90
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	9,976,720.00	15,179,200.00
35410	Бичиг хэргийн материал	1,222,000.00	927,000.00
35420	Аж ахуйн материал	651,500.00	759,000.00
35460	Хүнсний материал	8,103,220.00	13,493,200.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,646,666,905.76</b>	<b>1,673,406,399.20</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	1,646,666,905.76	1,673,406,399.20
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	1,638,886,905.76	1,660,216,399.20
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,763,157,158.00	1,763,157,158.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(166,870,599.00)	(221,016,491.04)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	64,185,453.00	106,201,257.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(48,415,454.88)	(53,489,013.61)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	63,442,458.00	99,066,602.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(38,452,407.62)	(38,482,411.41)
39217	Ном	1,840,298.26	4,779,298.26
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	7,780,000.00	13,190,000.00
39301	Програм хангамж	550,000.00	550,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(550,000.00)	(550,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	7,780,000.00	13,190,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>1,756,324,168.02</b>	<b>1,873,932,037.07</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>7,439,823.61</b>	<b>1,429,619.53</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	7,439,823.61	1,429,619.53
<b>413</b>	<b>Өглөг</b>	7,439,823.61	1,429,619.53
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	794,129.61	1,429,619.35
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	6,645,694.00	0.18
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,748,884,344.41</b>	<b>1,872,502,417.54</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	1,748,884,344.41	1,872,502,417.54
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	170,404,385.00	175,814,385.00
51101	Өмч: - төрийн	170,404,385.00	175,814,385.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	1,152,387,994.50	1,270,596,067.63
51210	Өмнөх үеийн үр дүн	1,152,387,994.50	1,152,387,994.50
51220	Тайлант үеийн үр дүн	-	118,208,073.13

Цэцэг сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	426,091,964.91	426,091,964.91
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>1,756,324,168.02</u></b>	<b><u>1,873,932,037.07</u></b>

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

(Төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,177,264,433.00</b>	<b>1,371,555,913.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>334,011,433.00</b>	<b>87,141,213.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	334,011,433.00	87,141,213.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	11,225,000.00	87,141,213.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	11,225,000.00	87,141,213.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-ҮХ	322,786,433.00	-
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>843,253,000.00</b>	<b>1,284,414,700.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	760,939,800.00	1,155,850,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	760,939,800.00	1,155,850,700.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	-	22,056,800.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	22,056,800.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	82,313,200.00	106,507,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	82,313,200.00	106,507,200.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>851,880,322.87</b>	<b>1,253,347,839.87</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>851,880,322.87</b>	<b>1,253,347,839.87</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	844,154,422.87	1,232,860,839.87
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	542,080,581.98	828,646,879.88
210101	Үндсэн цалин	373,348,474.30	532,613,822.88
210102	Нэмэгдэл	129,529,541.63	242,560,817.00
210104	Урамшуулал	39,202,566.05	53,472,240.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	68,413,596.59	104,106,399.75
210201	Тэтгэврийн даатгал	46,735,172.56	70,928,795.11
210202	Тэтгэмжийн даатгал	5,420,805.85	8,286,468.20
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,336,644.67	4,174,965.93
210204	Ажилгүйдлийн даатгал	1,079,361.88	4,143,234.11
210205	Эрүүл мэндийн даатгал	10,841,611.63	16,572,936.40
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	83,086,034.00	103,457,577.00
210301	Гэрэл, цахилгаан	6,408,534.00	5,251,977.00
210302	Түлш, халаалт	76,206,300.00	98,205,600.00
210303	Цэвэр, бохир ус	471,200.00	-
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	2,108,400.00	3,361,507.50
210401	Бичиг хэрэг	661,832.00	2,851,600.00
210402	Тээвэр, шатахуун	-	509,907.50
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,446,568.00	-
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	85,353,082.00	85,380,460.00
210502	Хоол, хүнс	85,353,082.00	85,380,460.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	1,040,000.00	5,357,689.00

Цэцэг сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210604	Урсгал засвар	1,040,000.00	5,357,689.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1,168,700.00</b>	<b>7,719,600.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	6,351,200.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,168,700.00	1,368,400.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>60,904,028.30</b>	<b>94,830,726.74</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	10,638,868.00	25,999,907.18
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,458,300.00	2,973,200.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	47,806,860.30	65,857,619.56
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>7,725,900.00</b>	<b>20,487,000.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>7,596,800.00</b>	<b>20,487,000.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	7,596,800.00	20,487,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>129,100.00</b>	<b>-</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	129,100.00	-
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b><u>325,384,110.13</u></b>	<b><u>118,208,073.13</u></b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b><u>325,384,110.13</u></b>	<b><u>118,208,073.13</u></b>

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

(Төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b><u>843,253,000.00</u></b>	<b><u>1,284,414,700.00</u></b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>843,253,000.00</b>	<b>1,284,414,700.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	760,939,800.00	1,155,850,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	760,939,800.00	1,155,850,700.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	-	22,056,800.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	22,056,800.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	82,313,200.00	106,507,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	82,313,200.00	106,507,200.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b><u>804,256,815.54</u></b>	<b><u>1,217,168,445.89</u></b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>804,256,815.54</b>	<b>1,217,168,445.89</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>796,530,915.54</b>	<b>1,196,681,445.89</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	538,976,215.54	827,011,145.89
210101	Үндсэн цалин	359,618,784.93	494,481,947.80
210102	Нэмэгдэл	141,437,905.93	266,646,177.70
210104	Урамшуулал	37,919,524.68	65,883,020.39
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	69,749,400.00	103,614,900.00
210201	Тэтгэврийн даатгал	47,429,500.00	70,458,100.00
210202	Тэтгэмжийн даатгал	5,580,000.00	8,289,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,464,000.00	4,144,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,116,100.00	4,144,600.00

Цэцэг сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210205	Эрүүл мэндийн даатгал	11,159,800.00	16,578,400.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	81,144,100.00	105,167,200.00
210301	Гэрэл, цахилгаан	4,466,600.00	5,896,000.00
210302	Түлш, халаалт	76,206,300.00	98,205,600.00
210303	Цэвэр, бохир ус	471,200.00	1,065,600.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	77,335,200.00	95,474,200.00
210502	Хоол, хүнс	77,335,200.00	95,474,200.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	1,040,000.00	1,340,000.00
210604	Урсгал засвар	1,040,000.00	1,340,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	1,168,700.00	13,425,200.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	12,056,800.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,168,700.00	1,368,400.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	27,117,300.00	50,648,800.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	23,862,100.00	42,454,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,255,200.00	8,194,800.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>7,725,900.00</b>	<b>20,487,000.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	7,596,800.00	20,487,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	7,596,800.00	20,487,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	129,100.00	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	129,100.00	-
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b><u>38,996,184.46</u></b>	<b><u>67,246,254.11</u></b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	38,996,184.46	67,246,254.11
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		38,781,104.46
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	38,781,104.46	106,027,358.57

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

(Төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	170,404,385.00	426,091,964.91	1,152,387,994.50	1,748,884,344.41
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	170,404,385.00	426,091,964.91	1,152,387,994.50	1,748,884,344.41
C08	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	170,404,385.00	426,091,964.91	1,152,387,994.50	1,748,884,344.41
D01	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	170,404,385.00	426,091,964.91	1,152,387,994.50	1,748,884,344.41
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	170,404,385.00	426,091,964.91	1,152,387,994.50	1,748,884,344.41

Цэцэг сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	5,410,000.00	-	-	5,410,000.00
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	118,208,073.13	118,208,073.13
D09	<b>2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>175,814,385.00</b>	<b>426,091,964.91</b>	<b>1,270,596,067.63</b>	1,872,502,417.54

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

(Төгрөгөөр)

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	1,323,195,800.00	1,217,168,445.89
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	1,323,195,800.00	1,217,168,445.89
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,302,708,800.00	1,196,681,445.89
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	920,928,200.00	827,011,145.89
210101	Үндсэн цалин	582,620,500.00	494,481,947.80
210102	Нэмэгдэл	296,102,200.00	266,646,177.70
210104	Урамшуулал	42,205,500.00	65,883,020.39
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	107,313,100.00	103,614,900.00
210201	Тэтгэврийн даатгал	72,974,900.00	70,458,100.00
210202	Тэтгэмжийн даатгал	8,583,100.00	8,289,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,292,400.00	4,144,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	4,292,400.00	4,144,600.00
210205	Эрүүл мэндийн даатгал	17,170,300.00	16,578,400.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	105,167,200.00	105,167,200.00
210301	Гэрэл, цахилгаан	5,896,000.00	5,896,000.00
210302	Түлш, халаалт	98,205,600.00	98,205,600.00
210303	Цэвэр, бохир ус	1,065,600.00	1,065,600.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	98,279,400.00	95,474,200.00
210502	Хоол, хүнс	98,279,400.00	95,474,200.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	1,340,000.00	1,340,000.00
210604	Урсгал засвар	1,340,000.00	1,340,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	14,733,600.00	13,425,200.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	12,056,800.00	12,056,800.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,676,800.00	1,368,400.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	54,947,300.00	50,648,800.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	46,752,500.00	42,454,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,194,800.00	8,194,800.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	20,487,000.00	20,487,000.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	20,487,000.00	20,487,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	20,487,000.00	20,487,000.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	1,323,195,800.00	1,284,414,700.00
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	1,155,850,700.00	1,155,850,700.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,155,850,700.00	1,155,850,700.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>22,056,800.00</b>	<b>22,056,800.00</b>

131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	22,056,800.00	22,056,800.00
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	106,507,200.00	106,507,200.00
132001	Орон нутгийн төсвөөс	106,507,200.00	106,507,200.00
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	38,781,100.00	-
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	38,781,100.00	-
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		<b>38,781,104.46</b>
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		<b>106,027,358.57</b>

### 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 133,335.1 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 25,804.1 мянган төгрөгийн бүртгэл тайлагналын алдаа<sup>1</sup>-г аудитын явцад залруулж, баталгаажуулав. Үүнд:

- Төсвийн гүйцэтгэлийн тайланд төлөвлөгөөг зөрүүтэй, мөнгөн гүйлгээний тайланд зардлыг зөрүүтэй тайлагнасан-7,743.9 мянган төгрөг.
- Үндсэн хөрөнгийн элэгдэл тооцоогүй, акталсан хөрөнгийг данс бүртгэлээс хасаагүй-18,060.2 мянган төгрөг.

Залруулагдаагүй нийт 12,056.8 мянган төгрөгийн 1 зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс бага, 95,474.2 мянган төгрөгийн 2 зөрчил нь нийцлийн асуудал байгаа тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 107,531.0 мянган төгрөгийн 3 зөрчил<sup>2</sup> илэрснээс, 107,531.0 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өгсөн.

#### 3.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

##### 3.1.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

*Илрүүлэлт:* Шилэн дансны системд 169 мэдээллийг хугацаанд нь, 2 мэдээллийн хугацаа болоогүй харагдаж байгаа боловч хандив тусламжийн орлого, төсвийн төсөл, хагас жилийн санхүүгийн тайланг мэдээлээгүй байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 6.1.4-д "хагас жилийн тайланг 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор;", "хандив, тусламжийн хэмжээ, түүний зарцуулалт"-ыг 8 сарын 15-ны дотор, 6.1.3-д "дараа жилийн төсвийн төслийг жил бүрийн 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор;" гэсэн заалтуудтай нийцээгүй.

*Өгсөн зөвлөмж:* Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг үнэн зөв мэдээлэх.

##### 3.1.2 Бараа материалын бүртгэлтэй холбоотой асуудал

*Илрүүлэлт:* Сүү хөтөлбөрийн хүрээнд худалдан авсан 12,055.8 мянган төгрөгийн сүүг бараа материалын тайланд тусгаагүй шууд зардалд бичсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2-т "бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага;"-ыг заавал бүртгэнэ, Сангийн сайдын 2025 оны 03 дугаар тушаалаар баталсан

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

“Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын наймдугаар бүлэгтэй нийцээгүй.

Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бараа материалын тайланг гаргах.

### 3.1.3 Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Тайлант онд хүүхдийн хоол хүнсэнд 95,474.2 мянган төгрөгийн хүнсний материалыг шууд гэрээ байгуулан худалдан авсан байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2-т “Энэ хуулийн 31.2-т зааснаас бусад тохиолдолд нийт төсөвт өртөг нь шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаараас хэтрээгүй бараа, ажил, үйлчилгээг захиалагч шууд худалдан авч болно” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн 02 дугаар тогтоолоор Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаарыг шинэчлэн тогтоосон тогтоолын дагуу босго үнээс давсан барааг худалдан авахдаа худалдан авах ажиллагааг зохион байгуулж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2025 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

##### 4.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдааны утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс:				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
								тоо	Дүн	тоо	Дүн		
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14
Цэцэг сумын Хүүхдийн цэцэрлэг	Төсвийн гүйцэтгэлийн тайланд төлөвлөгөө 3.859.000 төгрөгөөр зөрүүтэй, мөнгөн гүйлгээний тайланд зардлыг 3.848.011 төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан	1	7,743.9					1	7,743.9				
	Үндсэн хөрөнгийн элэгдэл тооцоогүй, акталсан хөрөнгийг данс бүртгэлээс хасаагүй.	1	18,060.2					1	18,060.2				
		<b>2</b>	<b>25,804.1</b>					<b>2</b>	<b>25,804.1</b>				

##### 4.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:							
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
Цэцэг сумын Хүүхдийн цэцэрлэг	Сүү хөтөлбөрийн хүрээнд худалдан авсан сүүг бараа материалын тайланд тусгаагүй шууд зардалд бичсэн	1	12,056.8					1	12,056.8		
	<b>Нийт дүн</b>	<b>1</b>	<b>12,056.8</b>					<b>1</b>	<b>12,056.8</b>		

## 4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:					
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	2	3	4	5	6	7	8	9	10
Цэцэг сумын Хүүхдийн цэцэрлэг	Шилэн дансны системд 169 мэдээллийг хугацаанд нь, 2 мэдээллийн хугацаа болоогүй харагдаж байгаа боловч хандив тусламжийн орлого, төсвийн төсөл, хагас жилийн санхүүгийн тайланг мэдээлээгүй байна.	1	-					1	-
	Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулаагүй	1	95,474.2					1	95,474.2
<b>Нийт дүн</b>		<b>2</b>	<b>95,474.2</b>					<b>2</b>	<b>95,474.2</b>

## 5. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан		Аудит хийгээгүй	7	8				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
<b>НИЙТ</b>		<b>1</b>	<b>1</b>			<b>1</b>			